



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Миний Монгол нам (ММН)-ын дүрэм
(шинэчилсэн найруулга)-ийг
бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа шүүгч Б.Амарбаясгалан, Б.Батцэрэн, Г.Банзрагч, Н.Батчимэг, Н.Батзориг, М.Батсуурь, Н.Баярмаа, Э.Золзаяа, Ц.Оч, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, Б.Ундрах, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Миний Монгол нам (ММН)-ын дүрэм (шинэчилсэн найруулга)-ийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч М.Батсуурийн танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Миний Монгол нам (ММН)-ын үүсгэн байгуулагч Ж.Бат-Ирээдүйгээс “намын Ээлжит бус Их хурлын 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 06 дугаар тогтоолоор Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу намын дүрэмдээ нэмэлт, өөрчлөлт (шинэчилсэн найруулга)-ийг оруулсан тул бүртгэж өгнө үү” гэх агуулга бүхий өргөдлийг 157 хуудас баримт, 1 ширхэг флашны хамт 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Улсын дээд шүүхэд ирүүлжээ.

Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын 2.5-д зааснаар Бүртгэлийн албанаас сонсох ажиллагаа явуулж, 107 хуудас баримт бичиг, тайлбарыг нэмэлтээр хүлээн авсан.

Миний Монгол нам (ММН)-ын дүрмийг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын дагуу шалгаж, нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд “Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-тай нийцүүлэх арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ” гэж заасан.

Миний Монгол нам өмнө нь дүрмийн өөрчлөлтөө бүртгүүлэх өргөдлийг 2 удаа ирүүлснийг Улсын дээд шүүхийн 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 04/2253 дугаар албан бичгээр 12 алдаа, зөрчил, 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 02/3644 дүгээр албан бичгээр 9 алдаа, зөрчлийн үндэслэлийг зааж буцаасан.

Тус нам нь дээрх албан бичгийн үндэслэлд дурдсан зөрчлийг бүрэн арилгаж, хуульд заасан хугацаанд намын дүрмийг шинэчлэн, хүчин төгөлдөр үйлчилж буй Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д заасан шаардлагад нийцүүлэн ирүүлсэн байх тул Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас тус намын дүрэм (шинэчилсэн найруулга)-ийг дараах үндэслэлээр бүртгэж шийдвэрлэлээ.

Нэг. Шийдвэр гаргах ажиллагааны тухайд:

1.1. Миний Монгол нам (ММН)-ын дүрэм (2019 он)-ийн 30 дугаар зүйлийн 30.3-т “Намын Их хурал хуралдах тов, төлөөлөгчдийн тоо, тэдгээрийг сонгох журмыг Бага хурал тогтооно”, 31.1-д “Намын Их хуралд сонгогдсон нийт төлөөлөгчдийн гуравны хоёроос илүү нь оролцож байгаа бол Их хурлыг хүчинтэйд тооцно”, 34 дүгээр зүйлийн 34.2-т “Намын Бага хурлын хуралдааныг ... эсхүл намын Бага хурлын гишүүдийн гуравны нэг шаардсанаар зарлан хуралдуулж болно”, 52 дугаар зүйлийн 52.1-д “Намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгын санал боловсруулах, хэлэлцүүлэх асуудлыг Удирдах Зөвлөлийн саналд үндэслэн намын Бага хурлаас намын Их хуралд өргөн барина” гэж тус тус заасан.

Миний Монгол нам (ММН)-ын Бага хурлын гишүүдийн гуравны хоёрын шаардлагын дагуу Ерөнхий нарийн бичгийн дарга Х.Оюунбаяр нь 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 18 дугаар албан бичгээр “Ээлжит бус Бага хурлыг 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр хуралдуулах”-аар, Удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 02 дугаар тогтоолоор намын дүрмийн нэмэлт, өөрчлөлт, хөтөлбөрийн төслийг боловсруулан намын Бага хурлаар хэлэлцүүлэх саналыг уламжилж, танилцуулахаар тус тус шийдвэрлэжээ.

Улмаар намын Ээлжит бус Бага хурал 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр хуралдаж, 03 дугаар тогтоолоор намын Ээлжит бус Их хурлыг 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хуралдуулахаар товлон зарлаж, төлөөлөгчдийн тоог нийслэл, орон нутгийн төлөөллөөс бүрдсэн нийт 31 төлөөлөгч байхаар тогтоож, 04 дүгээр тогтоолоор Их хурлын төлөөлөгчдийг сонгох журмыг баталсан бөгөөд хурлын зарыг намын гишүүд, дэмжигчдэд Өдрийн сонин (2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн №217 (7829) 6 дугаар тал), урилга, хөтөлбөрийг хүргүүлэн мэдэгдсэн байна.

Өргөдөлд хавсарган ирүүлсэн Ээлжит бус Их хурлын тэмдэглэл, тогтоол, нийслэл болон Төв, Ховд, Хөвсгөл аймгийн намын хорооны Тэргүүлэгчдийн тогтоол, гишүүний бүртгэл, татвар төлсөн мэдээлэл зэрэг баримтуудаас үзэхэд, тус намын 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Ээлжит бус Их хуралд нийт 31 төлөөлөгч оролцсон, үүнээс нийслэл-15, орон нутгийн төлөөлөл-16, эдгээр төлөөлөгчдийг намын гишүүн, төлөөлөгч мөн эсэхийг шалгахад зөрчилтэй зүйлгүй бөгөөд тухайн Их хурлыг хүчин төгөлдөр бусад тооцох үндэслэл тогтоогдсонгүй.

Иймд, өмнөх Улсын дээд шүүхийн 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 04/2253 дугаар, 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 02/3644 дүгээр албан

бичгийн үндэслэлд дурдсан “Нийслэлийн дүүргийн бага хурал, Сум, хороо, багийн бүх гишүүдийн хурлаас намын Их хурлын төлөөлөгчийг сонгож, намын хорооны гишүүнийг тодруулах” дүрмийн 16.1.8 дахь заалттай холбоотой зөрчил арилсан гэж үзэв.

Өөрөөр хэлбэл, тус намын даргын 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 23 дугаар албан бичгээр “Манай нам нь одоогийн байдлаар 1010 орчим гишүүний бүртгэлтэй бөгөөд Их хуралд төлөөлөгчөөр 31 хүн оролцсон, тэдгээр нь намын гишүүдийг бүрэн төлөөлнө. Тухайлбал, намын дүрэмд Их хуралд оролцох төлөөлөгчийн тоог заагаагүй, Их хурлыг болохоос өмнө ажлын албаны хүмүүс 5 бүс тус бүрээр биечлэн очиж, намын гишүүдтэй нэг бүрчлэн уулзаж, хэлэлцүүлэг хийж, тэдгээрийн саналыг тусган ажилласан, Бага хурлаас Их хурлын төлөөлөгч сонгох журмыг батлахдаа татвараа тогтоосон хугацаанд нь төлдөг байх, татварын өргүй намын гишүүнийг сонгох шаардлагатай гэж шийдвэрлэсэн, тус журмын шаардлагыг хангасан 40 орчим гишүүн байгаа, бусад гишүүд татвараа огт төлөөгүй” гэх тайлбар гаргасан болно.

1.2.Миний Монгол нам (ММН)-аас 2025 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн Ээлжит бус Их хурлын 04 дүгээр тогтоол, хавсралтаар Бага хурлын 13 гишүүнийг баталж, нэрсийн жагсаалтыг шүүхэд ирүүлсэн. Эдгээр гишүүдийн 10 нь Бага хурлыг нэн яаралтай хуралдуулахыг шаардсаны дагуу Ээлжит бус Бага хурал 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хуралдаж, тус хуралд 13 гишүүн оролцохоос 12 оролцож, хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар намын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсан нь дүрмийн 34 дүгээр зүйлийн 34.2-т заасантай нийцжээ.

Хоёр. Намын дүрэм (шинэчилсэн найруулга)-ийн тухайд:

Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” 17.2.1-д “намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж, тус намын дүрэм (2019 он)-ийн 13.4-т “Хурлын ирц Бүх шатны намын байгууллагын хурлын хувьд дүрэм, бусад журамд өөрөөр заагаагүй бол таслах эрхтэй нийт гишүүдийн ердийн олонх, ... оролцсоноор шийдвэрлэнэ. Бусад тохиолдолд хурлын шийдвэр нь дүрэм, бусад журамд өөрөөр заагаагүй бол хуралд оролцогчдын ердийн олонхын саналаар хүчин төгөлдөр болно”, 30 дугаар зүйлийн 30.4-т “Намын Их хурал намын бодлогын ямар ч асуудлыг хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.”, 30.4.1-д “Намын дүрэм, ... мөрийн хөтөлбөр, ... батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж тус тус заажээ.

Миний Монгол нам (ММН)-ын 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Ээлжит бус Их хурлаар намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэж, саналыг дэмжих томъёоллоор санал хураах (мандат өргөн)-д Их хуралд оролцсон 31 төлөөлөгчийн 100 хувийн саналаар дэмжиж, 06 дугаар тогтоолоор намын дүрмийн шинэчилсэн найруулгыг батлан шийдвэрлэсэн нь Тооллогын комиссын тогтоол, Ээлжит бус Их хурлын тогтоол, хурлын тэмдэглэл, фото зураг, дүрс бичлэг зэрэг баримтуудаар тогтоогдож байна. Гэвч дотоод аудиторыг нөхөн томилох, төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг хуваарилах, хуваарилахгүй байх шалгуур,

нөхцөл, хувь хэмжээг тухайн шинэчилсэн дүрэмд тодорхой тусгаагүй байсан. Иймд Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар дээрх зөрчлийг зааж буцаасан.

Харин 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Ээлжит бус Бага хурлын 03 дугаар тогтоол, хавсралтаар дээрх Ээлжит бус Их хурлыг 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан намын дүрэм (шинэчилсэн найруулга)-ийн 13.8, 33.2.15 дахь заалтыг өөрчилж, 39.6 дахь хэсгийг нэмж оруулах саналыг Бага хурлын гишүүдийн 100 хувийн саналаар дэмжсэн нь Хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т “Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна” гэж заасантай нийцсэн гэж үзлээ.

Тодруулбал, Намын дүрмийн 13 дугаар зүйлийн 13.8-д “Улс төрийн намын тухай хуулийн 8.2.3-д заасны дагуу нам гишүүдээ намын удирдах байгууллага, албан тушаал, сонгуульд нэр дэвших, сонгох, томилоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байж, тэгш боломж олгох ба нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байна. Намын төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна”, 33 дугаар зүйлийн 33.2.15-д “Намын санхүүгийн тайланг хянан шалгах нэг, эсхүл түүнээс дээш тооны дотоод аудиторыг 4 жилийн хугацаагаар нууц санал хураалтаар томилох, чөлөөлөх, нэг удаа дахин томилох, нөхөн томилох” гэж өөрчилж, 39 дүгээр зүйлийн 39.6-д “Энэхүү дүрмийн 39.5-д заасан этгээдээс намын салбар бүтцийн байгууллага болон намын гишүүдийн сонирхлын бүлгээс Удирдах зөвлөлд ирүүлсэн төслийг Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэр гаргахдаа тус дүрмийн 39.4-т заасан хувь харьцааг баримтлах бөгөөд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг энэ дүрмийн 39.4-т зааснаас бусад зорилгоор ашиглахыг хориглоно” гэж нэмсэн байна.

Иймээс, Миний Монгол нам (ММН)-ын дүрэм (шинэчилсэн найруулга) нь бүхэлдээ Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан намын дүрэмд тавигдах нийтлэг шаардлага болон намын дүрмээр тусгайлан зохицуулах асуудлыг тусгасан байх тул бүртгэх хууль зүйн үндэслэлтэй гэж үзлээ.

Миний Монгол нам (ММН)-ын хөтөлбөр хуульд нийцсэн болохыг дурдав.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь заалтыг баримтлан Миний Монгол нам (ММН)-ын дүрэм (шинэчилсэн найруулга)-ийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

М.БАТСУУРЬ